АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ЭРҮҮЛ
МЭНДИЙН ГАЗАР

ЭРҮҮЛ
МЭНДИЙН
САЛБАР

# УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН 2024

**Сэдэв: СУМ, ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ, АНХААРАХ АСУУДАЛ**

2024.05.02-03

ЭМГ-ХШҮМХ-ийн Хяналт үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн, хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цагаанцэнд

# АГУУЛГА

-Хяналт шинжилгээ үнэлгээний бодлогын баримт бичиг

-Статистикийн үзүүлэлт холбогдох тушаал, программ

-Цаашид анхаарах асуудал

**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ**

2021 оны 10 сарын 05 өдөр Дугаар А/605 Улаанбаатар хот

Журам, аргачлал батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны Журам шинэчлэн батлах тухай 206 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг нэгдүгээр, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнах хугацааг хоёрдугаар, холбогдох баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнах хүснэгтийг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг яамны газар, хэлтэс, харьяа эрүүл мэндийн байгууллага, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, ерөнхий захирал нарт үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн салбарын холбогдох эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнах мэдээллийн цахим сан үүсгэж, тогтмол ажиллагааг хангахыг Бодлого төлөвлөлтийн газарт даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Ц.Эрдэмбилэг)-д даалгасугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/422 дугаар тушаал, 2018 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/518 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД С.ЭНХБОЛД

**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ**

2021 оны 09 сарын 15 өдөр Дугаар А/578 Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 302 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрүүл мэндийн салбараар үйлчлүүлж буй хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ хийх журам"-ыг нэгдүгээр, үнэлгээний асуумжийг хоёрдугаар хавсралтаар тус тус батлалсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Жил бүр улсын хэмжээнд хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээг зохион байгуулах, шаардагдах зардлыг жилийн төсөвтөө тусган батлуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Ц.Эрдэмбилэг)-д даалгасугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 13 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД С.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 07 сарын 01 өдөр Дугаар А/346 Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны Журам шинэчлэн батлах тухай 206 дугаар тогтоол, 2021 оны Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 374 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг нэгдүгээр, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаа тайлагнах хугацааг хоёрдугаар, холбогдох баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнах хүснэгтийг гуравдугаар хавсралтаар тус тус батласугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг яамны газар, хэлтэс, харьяа эрүүл мэндийн байгууллага, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, ерөнхий захирал нарт үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн салбарын холбогдох эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнах мэдээллийн цахим сан үүсгэж, тогтмол ажиллагааг хангахыг Бодлого төлөвлөлтийн газарт даалгасугай.

4. Жил бүр улсын хэмжээнд хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээг зохион байгуулж, дүн тайланг журмын дагуу эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлж байхыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Ц.Эрдэмбилэг)-д даалгасугай.

6. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн А/605, 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн А/578 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД С.ЭНХБОЛД

ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 20 өдөр Дугаар А/15 Даланзадгад сум

Журам, аргачлал шинэчлэн батлах тухай

Засгийн газрын 2020 оны Журам шинэчлэн батлах тухай 206 дугаар тогтоол, Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн сайдын "Журам шинэчлэн батлах тухай" 2022 оны А/346 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, хяналт шинжилгээ хийх журмыг нэгдүгээр, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх үнэлгээний хүрээ, шалгуур, мэдээллийн эх үүсвэр, тайлагнах хугацааг хоёрдугаар, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийг гуравдугаар хавсралтаар тус тус батласугай.

2.Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын дарга нар, Эрүүл мэндийн газрын хэлтсийн дарга, мэргэжилтнүүдэд үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Б.Цагаанцэнд)-д даалгасугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны А/59 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Ц.ЖАВЗАНДУЛАМ

# ЭМС 2022 оны А/346 тушаалын дагуу эрүүл мэндийн салбарыг

- Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт
- Төрийн албан хаагчийн сургалт ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт
- Мэдээллийн ил тод нээлттэй байдлын хэрэгжилт
- Хэрэглэгчийн үнэлгээ

УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН 2024

## Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны А/15 дугаар тушаал

- Байгууллагын удирдлага, хөгжил
- Хүний нөөц
- Санхүүгийн удирдлага
- Мэдээллийн удирдлага
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
- Хяналт шалгалт

# Хяналт шинжилгээ-үнэлгээний үр дүн- хариуцлага

1. Эрүүл мэндийн байгууллага нь үнэлгээний дүн, зөвлөмжтэй танилцан сайжруулах асуудлаар “Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө”-г баталж, хэрэгжүүлнэ.
2. Гүйцэтгэлийн үнэлгээний дүнгээр хамгийн өндөр оноо авч тэргүүлсэн болон “Маш сайн” үнэлгээ авсан эрүүл мэндийн байгууллагыг Салбарын Оны тэргүүний байгууллагаар өргөмжлөж шагнаж урамшуулна.
3. “Маш сайн”, “Сайн үнэлгээ” авсан гурван байгууллагын удирдах ажилтнуудад цалин нэмэх, салбарын шагналаар шагнах, төрийн одон, медальд нэр дэвшүүлэх, удирдаж буй байгууллагын үйл ажиллагааг хөгжүүлэхэд чигэлсэн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэгт санал оруулах, дэмжиж тодорхойлж ажиллана.
4. Үнэлгээний дүнгээр “Дутагдалтай”, “Хангалтгүй” гэж дүгнэгдсэн байгууллагын удирдлагыг удирдлагын сургалтад хамруулах, дэмжлэгт удирдлагаар хангах ба шаардлагатай гэж үзвэл холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох
5. Шагнал, урамшуулалд зарцуулах хөрөнгийг орон нутгийн төсөв хөрөнгө болон бусад хандив тусламжаар шийдвэрлэнэ.

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 03 сарын 15 өдөр Дугаар А/122 Улаанбаатар хот

Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журмыг батлах тухай

Монгол Улсын Засгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 5.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам"-ыг нэгдүгээр, "Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гэрээний загвар"-ыг хоёрдугаар, "Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт"-ийг гуравдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэж, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар (А.Өнөржаргал)-т, Санхүү, эдийн засгийн газар (Л.Лувсан)-т даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2022 оны 02 дугээр сарын 22-ны өдрийн А/104 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.

С.ЧИНЗОРИГ

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 08 сарын 10 өдөр Дугаар А/283 Улаанбаатар хот

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний журам, жагсаалт, гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 хэсэг, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний журам"-ыг нэгдүгээр, "Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт"-ыг хоёрдугаар, "Анхан шатны тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт"-ийг гуравдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Бодлого төлөвлөлтийн газар (П.Оюунцэцэг), Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар (Д.Баярболд)), Нийтийн эрүүл мэндийн газар (А.Өнөржаргал) -т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, Өрх сум, тосгоны эрүүл мэндийн төвийн дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т даалгасугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/129, 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/52 дугаар тушаалыг тус тус хүчингүйд тооцсугай.

С.ЧИНЗОРИГ

# Өрхийн эрүүл мэндийн төв үнэлэх 2024 оны А/122 тушаал хариуцлага

- 1.Гэрээний үнэлгээний дүнг “хангалттай”-80-с дээш , “хангалтгүй”-79-с доош гэсэн 2
- хэлбэрээр дүгнэхээр өөрчлөлт оруулж, “ажил сайжруулах” гэдэг
- үнэлгээ хасагдсан.
- 2.Гэрээний хэрэгжилтийн хагас жилийн үнэлгээгээр “хангалтгүй”
- үнэлэгдсэн төвийн даргыг солих арга хэмжээ авахаар туссан.
- 3.Үнэлгээний үндсэн үзүүлэлтээс гадна нэмэлт шалгуурыг шинээр
- оруулсан
- 4.Гэрээ дүгнэх ажлын хэсэгт үйлчлэх хүрээний иргэдийн төлөөллийг оруулахаар тусгасан.
- 5.Гэрээг цахим болон үнэлгээний баг газар дээр нь очиж үнэлэх гэсэн 2 хэлбэрээр дүгнэх бөгөөд Нийт 5 бүлэг 63 шалгуур үзүүлэлтийг эрүүл мэндийн салбарын бодлогод нийцүүлэн тооцож, харьцуулж болохуйцаар томьёолсон, бусад шалгуурыг үйл ажиллагааг үнэлэхэд чиглүүлсэн болно.
- 6.Мэдээллийн ил тод байдал, “Цахим засаглал”-ын бодлогод
- нийцүүлсэн шалгуур орсон

## ЭМС-н 2019 оны А/611 дүгээр тушаал өөрчлөлт орохоор санал боловсруулагдаж байна

- Эрүүл мэндийн салбарт шатлалд бүрт давхардсан тоогоор бүртгэлийн **273** маягт хөтлөгдөж байгаагаас:
  - өрх, сумын эрүүл мэндийн төвд 51,
  - амбулаторид 59,
  - стационарт 86,
  - төрөлжсөн мэргэшлийн төв, тусгай мэргэжлийн төвүүдэд 77 маягт тус тус байна.
- Эрүүл мэндийн байгууллагад хөтлөгдөж буй дээрх 273 маягтад нийтдээ 3512 асуумж байгаа ба эдгээр нь 1-52 маягтад давхардсан байдлаар орж байгаа тул эдгээрийн давхардлыг арилгахад бүртгэлийн маягтын тоог 50 хувь бууруулах тооцоолол гарсан.
- Давхардсан агуулгатай маягтыг нэгтгэх, мэдээллийг товч тодорхой болгох зорилго тавьж, бүртгэлийн маягтад тусгагдсан асуумжийг бусад маягтуудад давхардахгүй байхаар боловсруулж байна.
- Бүртгэлийн нийт 273 маягтыг 150 маягтад нэгтгэн оруулж мэдээллийн давхардлыг арилгаж, цахим хэлбэрт оруулахад шаардлага хангах хэлбэрээр шинэчлэн боловсруулж байна.

- Бүх ЭМБ-дад маягтыг хүргүүлж санал авсан, санал өгсөн 2 байгууллага
- Санал өгөх хугацаа дуусч байгаа тул санал байвал ирүүлэх

УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН 2024

# Н info-3.0 программ хангамжид орсон өөрчлөлт

- Нас баралтын мэдээллийн сан- Улсын бүртгэлтэй холбогдсон - мэдээллийг бүрэн зөв оруулах
- Үр хөндөлтийн мэдээний бааз шинээр орж ирсэн- АМ19 - бүх үр хөндөлтүүдээ шивнэ. Хэрэв ор хоног ээлж хэвтсэн бол СТ-2 программ дээр давхар шивнэ.
- Цаашид СТ36, АМ14, АМ27, СТ1, ӨЭ2,8,10 мэдээллийн баазуудыг ашиглаж Жирэмсэн, настан, өрхийн хүн ам, ХБИ, Сэтгэцийн асуудалтай хүмүүсээ шивдэг болно

# Эрүүл мэндийн мэдээлэл цуглуулах боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журам

Сонсох / Сонгосон утга сонсох | Pdf | Word | Хэвлэх | Хуваалцах

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2024 оны 03 сарын 06 өдөр** | Дугаар 100 | Улаанбаатар хот

**ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ**

Эрүүл мэндийн тухай хуулийн 8.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД С.ЧИНЗОРИГ

# Эрүүл мэндийн мэдээлэл цуглуулах боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журам

- 1 дүгээр хавсралт

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар нь

- 2 дугаар хавсралт

Эрүүл мэндийн

| | |
|---|---|
| 89. | Вакцины гэрчилгээ |
| 90. | Олон улсын аяллын эрүүл мэндийн гэрчилгээ- International Travel Healt Certificate |
| 91. | Олон улсын аяллын эрүүл мэндийн гэрчилгээ- International Travel Healt Certificate (албан болон дипломат паспортоор) |
| 92. | Олон улсын аяллын эрүүл мэндийн гэрчилгээ- International Travel Healt Certificate (гадаад иргэнд) |
| 93. | Эмнэлгийн магадалгаа |
| 94. | Шинжилгээний хариу |
| 95. | Цусны бүлгийн мэдээлэл |
| 96. | Ковид-19 шинжилгээний хариу |

**ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН СИСТЕМЭЭР ДАМЖУУЛАН МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦАГЧААС ОЛГОХ ЛАВЛАГАА, ТОДОРХОЙЛОЛТЫН ЗАГВАР**

2023 оны 01 дүгээр сарын ... -ны өдөр

Засгийн газрын ... оны ... дугаар тогтоолын
... дугаар хавсралт

Хүсэлт гаргасан хэлбэр: Төрийн үйлчилгээний нэгдсэн систем

Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс олгосон давтагдашгүй дугаар бүхий цахим баримт бичиг нь цаасан баримт бичгийн нэгэн адил хүчинтэй байна.

Мэдээлэл хариуцагч байгууллагын холбоо барих утас: ...............

Мэдээлэл хариуцагч байгууллагын хаяг: ...........

# Цаашид анхаарах

- Аймгийн Засаг даргын захирамж, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, Эрүүл мэндийн газрын даргын тушаал шийдвэр болон ЭМГдаргын 2024 оны А/15 дугаар тушаалын хэрэгжилт хангаж ажиллах
- Албан хаагчдыг хөгжүүлэх мэргэшүүлэх, нийгмийн баталгааг хангах тогтвор суурьшилтай ажиллуулах
- Байгууллагын гүйцэтгэлийн тайланг баталгаажуулж албажуулж ирүүлэх
- Мэдээллийн ил тод нээлттэй байдал
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ чанарын үзүүлэлт ЭМС 2022 А/346 тушаалын 3 дугаар хавсралт
- ЭМС 2019 оны А/611 тушаал анхан шатны бүртгэл маягт бүрэн хөтлөж хэвших
- Зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж тайланг чанартай ирүүлэх
- Эрүүл мэндийн яамнаас тушаал журамд өөрчлөлт оруулах санал идэвхитэй оролцох.

УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН 2024

# Хэрэглэгчийн үнэлгээг ЭМБ-ын тухайн жилийн гүйцэтгэлийн хяналт шинжилгээ үнэлгээнд шууд ашиглахаар ЭМС 2022 А/346 тушаалын 5.8, 5.8.4 тусгагдсан 2023 онд 91,6 хувь



# Анхаарал хандуулсанд баярлалаа!

